

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-04-15

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 04 дүгээр сарын 23-ны “Лхагва” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Засгийн газрын 2025 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.	СТСХ, ХААА
2	Засгийн газраас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд саналаа тодорхой тусгаж, хүргүүлэх.	НХХ, Боловсролын хэлтэс
3	2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 08:00 цагт СТӨ-нд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх чиглэлээр Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах тул холбогдох албан хаагчид оролцох.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, СТСХ, ХААА
4	Нийслэлийн хэмжээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Дэлхийн цирк”-ийг үзүүлэх ажлыг зохион байгуулах.	НХХ, Соёлын ордон, ЕБС-иуд
5	Инженер хангамжийн байгууллагууд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Нийслэл Улаанбаатар хотын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженер хангамжийн байгууллагууд

6	Нийтийн эзэмшлийн талбайг хашаалсан автомашины зогсоолыг чөлөөлж, ТҮЦ, хашаа, хайс, гарааш буулгах ажлыг эрчимжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Цагдаагийн хэлтэс
7	Дулааны улирал ирж, хүүхэд, залуучуудын хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8	“Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Хороод, нийт байгууллагууд
9	Дүүргийн Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-уудын үйл ажиллагааг идэвхжүүлэх;	НХХ, Биеийн тамир, спортын хороо
10	Дүүргийн харьяат оюутнуудыг дүүрэг, орон нутагт ажиллаж амьдрах боломж нөхцөлийг ханган төгсөх курсын оюутнуудтай холбогдох гэрээг байгуулах;	НХХ, Хороод
11	Нийтийн эзэмшлийн гудамж, талбай дахь самбар, барилгын хашааг цэгцлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ,
12	“Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх жил-2025” зорилтот жилийн хүрээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр байгууллагуудад хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний мэдээллийг хуваарийн дагуу танилцуулах;	НХХ, Нийт байгууллагууд
13	Нийтийн эзэмшлийн гудамж, талбай дахь кабелин утас, шонг тэгшлэх, янзлах;	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв ОНӨТҮГ, эрчим хүчний байгууллагууд
14	Урин дулааны улирал эхэлж иргэд, оршин суугчид ойролцоох уул, овоонд алхах, агаарлахтай холбогдуулан “Тахилгат уул, овоо”-ны орчныг цэвэрлэх, таатай нөхцөлийг бүрдүүлэх;	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
15	Аж ахуйн, нэгж байгууллагууд орчныхоо өнгө үзэмжийг нэмэгдүүлэх хүрээнд тарьж ургуулсан мод, бутны цэнэг усалгааг хийж, хаврын “Мод тарих аян”-ыг эхлүүлэхэд бэлтгэх;	ЗДТГ, Дүүргийн менежер Г.Дагвадорж, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
16	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд ил задгай буулгасан шороо, хайргын зөрчлийг холбогдох байгууллага, иргэнээр арилгуулах	ТХҮХ, Газар зохион байгуулалтын алба
17	Хороодод шинээр хийгдэх тохижилтын ажлуудын судалгааг гарган танилцуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх.	Хороод
18	ОНӨААТҮГ-ууд хариуцсан ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	Илч-Орд, Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ

ХЯНАСАН
ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБАЯР